



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Говьсүмбэр аймгийн 2017 оны нэгдсэн
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



Төсвийн тухай хуульд заасан нөхцөл,
шаардлагыг баримтлахгүйгээр төвлөрсөн
орлогын хэмжээтэй уялдуулан зарлагыг
нэмэгдүүлж, төсөвт өөрчлөлт
оруулсан байна.

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар4
Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....5
Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа	Бүлэг 1. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөгөөг оны эцэст орлого, зарлагын гүйцэтгэлд тохируулан тодотгон баталсан байна.
Аудитын менежер Г.Наранбаяр	1.1. 2017 оны төсвийн төслийг боловсруулахдаа Сангийн яамнаас өгсөн чиглэлийн заримыг нь бүрэн хангаж ажиллаагүй байна.
Ахлах аудитор Ц.Батсайхан	1.2. Орон нутгийн холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй байгаагаас төсвийн орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, батлуулаагүй байна.
2018 оны 04 дүгээр сар	1.3. Орон нутгийн төсвийн зарлагыг тооцоо судалгаагүй төлөвлөж, үндэслэлгүй нэмэгдүүлсэн байна.
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3151, 7054-3179 дугаарын утсаар харилцана уу.	1.4. Орон нутгийн төсвийн тэнцлийн алдагдлыг нөхөх эх үүсвэрийг үнэн зөв тооцсон байна.
ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 давхар, 217 тоот	Бүлэг 2. Орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 761.2 сая төгрөг буюу 16.9%-иар давж биелсэн байна.
	2.1. Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 15.6% буюу 636.6 сая төгрөгөөр давж биелсэн байна.
	2.2. Орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 125.3 сая төгрөг буюу 29.4%-иар давж биелсэн боловч орлогын нэр төрлөөрөө тасарсан байна.
	2.3. 2017 онд улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг аваагүй байна.
	2.4. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг бүрэн санхүүжигдсэн байна.
	2.5. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийг бүрэн олгосон байна.
	2.6. Тэнцлийн ашгийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.
	Бүлэг 3. Төсвийн хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан боловч зарим зардлыг үр ашиггүй зарцуулсан байна.
	3.1. ТЕЗ-ийн батлагдсан төсөв нийт дүнгээрээ хэмнэгдсэн хэдий ч, төсвийн зарцуулалттай холбоотой зөрчил дутагдал байсаар байна.
	3.2. Тайлант хугацаанд ТЕЗ-ийн тайлангийн авлага өмнөх оноос 8.9%, өглөг 198.9%-иар тус тус өссөн байна.

3.3. Зөрчлийг илрүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагаа хангалтгүй, сургалт мэдээлэл дутмаг байна.

3.4. “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулж, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Дүгнэлт.....

Зөвлөмж.....

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
ГСА	Говьсүмбэр аймаг
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УБСГ	Улсын бүртгэл, статистикийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
АЗДНС	Аймгийн Засаг даргын нөөц сан
ОНӨҮААГ	Орон нутгийн өмчит үйлдвэр, аж ахуйн газар
ХК	Хувьцаат компани
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ХБГ	Хүлээгдэж байгаа гүйцэтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АМХБАТЗ	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл
ҮЭ	Үйлдвэрчний эвлэл
СХС	Сум хөгжүүлэх сан
БХС	Байгаль хамгаалах сан
МХС	Мал хамгаалах сан
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл: Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөө, Говьсүмбэр аймаг дахь Төрийн Аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт:

Говьсүмбэр аймгийн 2017 оны орон нутгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийж, дүнг ҮАГ, аймгийн ИТХ болон Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулах, давтан гаргуулахгүй байхад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын хамарсан хүрээ:

Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авдаг, орон нутгийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуйн нэгж, ТЭЗ-ийн 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэл, судалгаа мэдээлэл, бусад баримт материалуудад тулгуурлан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ аудитыг АДБОУС 1000-1800, Төрийн хяналт шалгалтын стандарт, Санхүүгийн аудитын гарын авлага, холбогдох журмуудыг ашиглахаас гадна холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулан авч, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан, нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль,
- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- Нийгмийн даатгалын багц хуулиуд
- Төрийн аудитын тухай хууль
- Татварын багц хуулиуд
- УИХ-ын 2015 оны 108 дугаар тогтоол
- УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоол
- Бусад холбогдох хууль тогтоомж, журам, заавар

Үндсэн мэдээлэл:

2017 онд орон нутгийн төсвийн орлогод 16,844.6 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна. Эх үүсвэрийн хувьд:

- орон нутгийн орлогоос 4,508.6 сая,
- ОНХС-ийн нэгдсэн сангаас санхүүжилт 1,178.1 сая,
- тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 8,091.6 сая,
- төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 1,256.7 сая,
- 2016 оны тэнцлийн ашиг 1,809.6 сая төгрөгийг тус тус бүрдүүлэхээр төсвийг алдагдалгүй төлөвлөсөн байна.

2017 онд аймгийн ТЕЗ-ийн төсвийг өмнөх оны гүйцэтгэлээс 37.3 сая төгрөгөөр бууруулж, нийт 16,844.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, баталсан ба 14,733.5 сая төгрөг зарцуулж, 2,111.0 сая төгрөгийн хэмнэлттэй мэт харагдаж байгаа боловч төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө 839.8 сая төгрөгөөр тасарсанаас зарлага санхүүжилт хийгдээгүй бөгөөд бодит хэмнэлт гэж үзэх үндэслэлгүй байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн байгууллагуудын хэмнэлтээр төлөвлөрүүлсэн 111.9 сая,
- Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүйгээс гүйцэтгэл гаргаагүй 0.2 сая,
- Татварын орлогын төлөвлөгөөг биелүүлээгүйгээс дутуу санхүүжсэн 2.0 сая,
- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын хэмнэлтээр төвлөрүүлсэн болон орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүйгээс гүйцэтгэл гараагүй нийт 158.8 сая
- ОНХС-ийн зарцуулагдаагүй үлдэгдэл 675.8 сая
- СХС-ийн зээлийн эргэн төлөлт хангалтгүйгээс зээл олголт 934.8 сая төгрөгийн зарлагын санхүүжилт хийгдээгүй
- Халамжийг сангийн гүйцэтгэл төлөвлөгдсөнөөс 164.3 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсан зэргээс тус тус шалтгаалжээ.

ТЕЗ-ийн 2017 оны нийт төсвийн гүйцэтгэлийн 54.3% буюу 6,741.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт байгууллага, 45.7% буюу 7,992.3 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төсөв эзэлж байна.

Орон нутгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн эсэх

Бүлэг 1

Орон нутгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөгөөг оны эцэст орлого, зарлагын гүйцэтгэлд тохируулан тодотгон баталсан байна.

1.1. 2017 оны төсвийн төслийг боловсруулахдаа Сангийн яамнаас өгсөн чиглэлийн заримыг нь бүрэн хангаж ажиллаагүй байна.

Монгол Улсын Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагууд нь макро түвшний асуудлууд учраас орон нутгийн түвшинд баримтлах боломжгүй юм.

Тус албан бичигт ТЕЗ нарын 2017 оны төсвийн төсөл, 2017-2018 оны төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамжид төсвийн алдагдлыг бууруулах зорилгоор төсвийн

орлого, нэмэгдүүлэх, зарлага бууруулах бодлого баримтлах шаардлага бий болсонтой холбоотой зарим зардлыг хязгаарлах шаардлагатай байгааг анхааруулсан байна. Үүнд:

1. Үүрэн телефон хэрэглэх эрх бүхий албан тушаалтнууд гар утасны төлбөрөө өөрсдөө хариуцан төлөх.
2. Төсвийн захирагч зардлын хэмнэлт болон үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоо зарцуулахдаа өр авлага үүсгэх, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулах, байнгын орон тоо, шинэ бүтэц бий болгох замаар урсгал зардал нэмэгдүүлэх, зочин төлөөлөгч хүлээн авах, гадаад томилолтын зардал санхүүжүүлэхийг хориглосон ба хэрэв зөрчсөн тохиолдолд төсвийн захирагчийг албан тушаалаас нь огцруулдаг байх.

Мөн Сангийн яамнаас 2017 оны төсвийн тодотгол хийхтэй холбоотой Сангийн сайдын 2017 оны 04 дугаар сарын 18-ний өдрийн 4-1/2168 дугаар бүхий албан бичгийг ирүүлсэн байна. Үүнд:

1. Төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2017 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах, цалин хөлсийг цаашид нэмэх асуудлыг 2019 оноос төсвийн боломжтой уялдуулан шийдвэрлэх
2. Төрийн албан хаагчид зэрэг, дэв олгох буюу зэрэг дэв ахиулах шийдвэрийг 2017-2019 онд гаргахгүй байх
3. Төрийн албан хаагчийн албан тушаалын зэрэглэл, шатлалыг ахиулахыг 2017-2019 онд түр зогсоох
4. 2017-2019 онд зөвхөн эрүүл мэнд боловсролын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаас 2 албан хаагч чөлөөлөгдсөн тохиолдолд нэг албан хаагчийг нөхөн томилох гэх мэт

Орон нутгийн түвшинд эдгээр чиглэлийг хэрхэн хангаж ажилласан талаар шалгуур болгож авч үзлээ.

Говьсүмбэр аймаг нь 2017 оны орон нутгийн төсвийн төлөвлөгөөг боловсруулж, гүйцэтгэлийг зохион байгуулах, төсвийн сар, улирлын хуваарийг боловсруулахдаа Сангийн яамнаас ирүүлсэн чиглэлийн заримыг нь хангаж ажиллаагүй байна. Тухайлбал:

- Халамжийн сангийн төсвийг үндэслэлгүй өндөр төлөвлөснөөс өмнөх онд 281.8 сая, тайлант онд 164.3 сая төгрөгийн хэмнэлт үүсч төвлөрүүлсэн байна.
- Аймгийн Баяр наадмыг тэмдэглэхэд АОНХС-гаас 20.0 сая, АЗДНС-гаас 21.5 сая, нийт 41.5 сая төгрөгийг зарцуулж, арга хэмжээний зардлыг 31.5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.
- Аймгийн Засаг даргын нөөц сангаас 2018 оны төсөв, төлөвлөгөө батлахтай холбоотойгоор ИТХТ-ийг хүлээн авч уулзалт зохион байгуулахад 2.0 сая аймагт Өмгөөлөх алба байгуулагдсаны 25 жилийн ойн баярыг тэмдэглэхэд дэмжлэг 0.3 сая, Монголын ҮЭ-ийн байгууллага үүсч хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэхэд дэмжлэг 5.0 сая, нийт 7.3 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Аймгийн хэмжээнд анх 14,735.0 сая төгрөгийн төсөв батлагдаж, 2 удаагийн төсвийн тодотголоор 2,109.5 сая төгрөгөөр нэмэгдэж, нийт 16,844.5 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. Төсвийн тодотголоор цалингийн зардлыг 91.7 сая, урсгал засвар 40.6 сая, сурталчилгааны зардал 0.5 сая, тоног төхөөрөмж худалдан авах зардлыг 36.4 сая, бичиг хэргийн зардлыг 0.4 сая, уралдаан тэмцээний зардлыг 1.5 сая, нийт 171.1 сая төгрөгөөр

төсвийг үндэслэлгүй нэмэгдүүлэн тодотгож, төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2. Орон нутгийн холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй байгаагаас төсвийн орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, батлуулаагүй байна.

Орон нутгийн төсвийн орлого, зарлагыг өмнөх онуудын суурь орлого, суурь зарлага болон төсөвт байгууллагуудын ирүүлсэн саналд үндэслэн төлөвлөдөг боловч төсвийн орлого, зардлыг хянаж, төлөвлөхөд ашиглах суурь судалгаа, тоон мэдээ багатайгаас төсвийн төлөвлөлт үндэслэлгүй хийгдэж байна.

2017 онд улсын төсөвт 1,932.0 сая, орон нутгийн төсөвт 4,508.6 сая төгрөг тус тус төвлөрүүлэхээр батлуулсан байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг өмнөх онтой харьцуулсан судалгааг графикаар харуулбал:



Графикаас харахад: 2017 оны улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 24.3% буюу 621.6 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн байна. Энэ нь 2016 оны НӨАТ-ын орлогын төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэлгүй батлуулснаас 34%-иар тасарсан, мөн 2017 онд ногдуулах НӨАТ-ын орлогын ногдуулалт болон төлөгдөх боломжийн судалгаа хийж бууруулан төлөвлөсөнтэй холбоотой байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөлтийг өмнөх жилүүдийн гүйцэтгэл болон тухайн жилийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байгаа боловч он дамжин төлөгдөх татварын авлагын тооцоо, тайлант онд шинээр үүсгэн байгуулагдаж, улсын бүртгэлд бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагуудын орлогын судалгааг үндэслэн улсын төсвийн орлогын боломжит эх үүсвэрүүдийг үнэн зөв, бүрэн тооцож, төлөвлөөгүй байна.

Тухайлбал: 2017 онд улсын төсвийн орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 621.6 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөн байхад гүйцэтгэлээр орлого 407.8 сая төгрөг буюу 21.1%-иар давж биелсэн байна.

2017 оны татварын зарим нэр төрлийн орлогыг үндэслэлгүй төлөвлөснөөс төсөвт 2 удаа тодотгол хийгдэж орон нутгийн орлогын төлөвлөгөөг нийт 2,109.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

2017 оны анх батлагдсан орон нутгийн орлогын төлөвлөгөөг сүүлийн тодотголоор батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

№	Орлогын нэр төрөл	АИТХ-аас анх баталсан 2017 оны орлого	Сүүлийн төсвийн тодотгол	Зөрүү
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	2 907,3	2 926,1	18,8
2	ХХОАТ-ын буцаан олголт	- 250,0	- 268,8	- 18,8
3	ҮХЭХ-ийн албан татвар	242,0	242,0	-
4	АТБӨЯХ-ийн албан татвар	80,0	84,0	4,0
5	Улсын тэмдэгтийн хураамж	52,0	52,0	-
6	Газрын төлбөр	90,0	90,0	-
7	Ус ашигласны төлбөр	585,5	585,5	-
8	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	-	-	-
9	Дуудлага худалдааны орлого	16,2	96,2	80,0
10	Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	35,0	35,0	-
11	Суутгагчийн хувь хүнд олгосон ОАТ	-	-	-
12	Үйл ажиллагааны орлого	142,1	144,5	2,4
13	Бууны албан татвар	4,5	4,5	-
14	ТТАМНАТ	4,7	4,7	-
15	Хог хаягдлын хураамж	86,5	86,5	-
Аймгийн татварын орлогын нийт дүн		3 995,8	4 082,2	86,4
1	Түрээсийн орлого	55,0	55,0	-
2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	54,1	148,8	94,7
3	Хүү, торгуулийн орлогр	250,0	371,3	121,3
Аймгийн татварын бус орлогын нийт дүн		359,1	575,1	216,1
1	Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	-	-	-
2	Тусгай зориулалтын шилжүүлэг	7 913,3	8 091,6	178,3
3	Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	1 185,4	1 178,1	- 7,3
Улсын төсвөөс авах шилжүүлгийн нийт дүн		9 098,7	9 269,7	171,0
1	ТЗШ-ийн байгууллагын өөрийн орлого	42,9	52,7	9,8
ТЗШ-ийн өөрийн орлогын нийт дүн		42,9	52,7	9,8
1	2016 оны тэнцлийн ашгаас /ОНХС/	-	798,8	798,8
2	2016 оны тэнцлийн ашгаас /Байгууллага/	-	217,5	217,5
2016 оны тэнцлийн ашгаас		-	1 066,4	1 016,4
1	2016 оны дансны үлдэгдэл /ОНХС/	218,6	793,2	574,6
2016 оны дансны үлдэгдэл /ОНХС/		218,6	793,2	574,6
1	Сумдын Сум хөгжүүлэх сан	988,2	1 035,8	47,5
2	Сумдын Байгаль хамгаалах сан	16,5	4,3	- 12,2
3	Сумдын Мал хамгаалах сан	15,2	15,2	-
Сумдын сангуудаас орох орлогын нийт дүн		1 019,9	1 055,2	35,3
НИЙТ ДҮН		14 735,0	16 844,6	2 109,6

Хүснэгтээс харахад: орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 14.3% буюу нийт 2,109.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Үүнээс орон нутгийн нийт орлого 4.8%, төсөвт байгууллагын өөрийн орлого 75.1%-иар тус тус нэмэгдсэн байна. Тухайлбал: 2017 оны төсөвт 2 удаа тодотгол хийсэн бөгөөд ОНХНС-гаас олгох шилжүүлгийг 7.3 сая, Сүмбэр сумын байгаль хамгаалах сангийн орлогын төлөвлөгөөг 12.2 сая төгрөгөөр тус тус бууруулж, АТБӨЯХ-ийн албан татварыг 4.0 сая, дуудлага худалдааны орлогыг 80.0 сая, үйл ажиллагааны орлогын 2.4 сая, орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагын өөрийн орлогыг 104.5 сая, хүү, торгуулийн орлогыг 121.3 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг 178.3 сая, сум хөгжүүлэх сангийн орлогыг 47.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, орлогын нэр төрөлд өөрчлөлт оруулсан байна.

Орон нутгийн орлогыг төлөвлөхдөө тайлант оны эцэст орлогын гүйцэтгэлд тохируулан тодотгон баталсан байна.

1.3. Орон нутгийн төсвийн зарлагыг тооцоо судалгаагүй төлөвлөж, үндэслэлгүй нэмэгдүүлсэн байна.

Говьсүмбэр аймгийн ТЕЗ-ийн 2016 оны ХБГ 14,704.0 сая төгрөг байсан ба 2017 оны төсвийн төсөлд 15,460.5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, санал


хүргүүлснээс УИХ-аас 13,058.7 сая төгрөгөөр батлагдаж ирсэн байна. Үүнд: Орон нутгийн суурь зарлага 3,761.7 сая, ТЗШ-ийн байгууллагын зарлага 7,944.2 сая, ОНХС-ийн зарцуулалт 1,052.0 сая, Улсын төсөвт төвлөрүүлэх орлого 167.4 сая төгрөгөөр тус тус батлагдсан байна.

Тайлант онд УИХ-аас батлагдсан 13,058.7 сая төгрөгийн зарлагын төсвийг аймгийн ИТХ 12.8% буюу 1,676.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 14,735.0 сая төгрөгөөр баталсан байна.

УИХ-аас батлагдаж ирсэн төсвийн зарлагыг нэмэгдүүлэхдээ: төсвийн суурь зарлагыг 6.7% хувь буюу 252.9 сая, ТЗШ-ийн байгууллагуудын төсвийг 0.15% хувь буюу 12.0 сая, ОНХС-ийн төсвийг 37.2% хувь буюу 391.5 сая, сумдын сангуудын төсвийг 100% буюу 1,019.9 сая төгрөгөөр тус тус нэмсэн байна.

Тайлант хугацаанд АИТХ анх баталсан төсвөө 2 удаа тодотгож, жилийн эцэст 7.9 хувь буюу 2,109.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 16,844.6 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

Нэмэгдсэн төсвийг салбар болон зардлын төрлөөр нь ангилж графикаар харуулбал дараах байдалтай байна.



Графикаас харахад: Орон нутгийн суурь зарлага 13.6% буюу 514.2 сая, ТЗШ-ийн байгууллагын зарлага 2.1% буюу 173.1 сая, ОНХС-ийн зарцуулалтыг 132% буюу 1,399.0 сая, СХС болон БХС, МХС-ийн зарцуулалтыг 3.4% буюу 35.3 сая, төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 7.2% буюу 12.1 сая төгрөгөөр бууруулсан байна.

2017 оны тодотгосон төсвийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулсан судалгааг дараах хүснэгтээр харуулбал:

№	Зардал бүлгийн төрлөөр	Өмнөх оны гүйцэтгэл	2017 оны сүүлийн тодотгосон төсөв	Зөрүү	
				Дүн	Хувь
	Нийт зарлага дүн	14,704.0	16,844.6	-2,140.5	-14.6
1	Цалин, нэмэгдэл урамшуулал	6,150.4	6,254.0	-103.6	-1.7
2	НДШ-ийн зардал	739.2	690.7	48.5	6.6
3	Тогтмол зардал	1,438.7	1,399.2	39.5	2.7
4	Хангамж бараа материалын зардал	263.1	253.2	9.9	3.8
5	Нормативт зардал	401.0	463.8	-62.8	-15.7

6	Эд хогшил, урсгал засварын зардал	100.0	161.6	-61.6	-61.6
7	Томилолт, зочны зардал	42.6	47.9	-5.3	-12.4
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	162.4	412.3	-249.9	-153.9
9	Бараа үйлчилгээний бусад зардал	961.6	1,107.1	-145.5	-15.1
10	Татаас	219.4	214.6	4.8	2.2
11	Бусад урсгал шилжүүлэг	1,675.6	2,396.3	-720.7	-43.0
12	Хөрөнгийн зардал	2,466.0	2,408.1	57.9	2.3
13	Эргэн олгох зээл	84.0	1,035.7	-951.7	-1,133.0

Хүснэгтээс харахад: Төсвийн зарлагыг нийт дүнгээр нь өмнөх оноос 14.6% буюу 2,140.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан бөгөөд үүнээс цалин, нэмэгдэл урамшууллын зардлыг 1.7% буюу 103.6 сая, нормативт зардлыг 15.7% буюу 62.8 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 61.6% буюу 61.6 сая, томилолт, зочны зардлыг 12.4% буюу 5.3 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 153.9% буюу 249.9 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 15.1% буюу 145.5 сая, бусад урсгал шилжүүлгийг 43% буюу 720.7 сая, эргэн олгох зээлийн зардлыг 1,133.0% буюу 951.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

ТЕЗ-ийн 2017 оны төсвийн төслийг боловсруулахдаа төсөвт байгууллага болон сумдын төсвийн саналыг авдаг боловч ирсэн саналд дүгнэлт, судалгаа шинжилгээ хийхгүй зөвхөн тоо, мэдээг нэгтгэх төдийгөөр хязгаарлагдаж байгаагаас орон нутгийн төсөв үндэслэлгүй төлөвлөгдсөөр байна. Үүнд:

- 2017 оны төсвийн зарлагыг өмнөх оны төсвөөс 16.5 сая төгрөг буюу 0.1%-иар нэмэгдүүлж баталсан байна. Тухайлбал: Цалин нэмэгдэл урамшууллын зардлыг 0.9% буюу 53.8 сая, нормативт зардлыг 11.8% буюу 48.9 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 61% буюу 61.2 сая, томилолт, зочны зардлыг 5.5% буюу 2.5 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 93.2% буюу 198.9 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 8.4% буюу 86.2 сая, бусад урсгал шилжүүлэгийн зардлыг 22.5% буюу 440.4 сая, эргэн олгох зээлийн зардлыг 11.5% буюу 106.9 сая, нийт 998.8 сая төгрөгөөр нэмэгжүүлж, НДШ-ийн зардлыг 7.5% буюу 55.9 сая, тогтмол зардлыг 5.0% буюу 73.3 сая, хангамжийн материалын зардлыг 4.8% буюу 12.8 сая, татаас шилжүүлэгийн зардлыг 3.4% буюу 7.6 сая, хөрөнгийн зардлыг 25.7% буюу 832.7 сая нийт 982.3 сая төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.
- Тайлант хугацаанд батлагдсан төсвийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлснээс төсвийн хэмнэлтийн горимыг баримтлан ажиллаагүй, урсгал зардлыг нэмэгдүүлэн баталсан байна. Тухайлбал: аймгийн ИТХ 37.9% буюу 96.9 сая, аймгийн ЗДТГ 16.2% буюу 116.4 сая, Сүмбэр сумын ЗДТГ 6.3% буюу 15.5 сая, Шивээговь сумын ЗДТГ 5.2% буюу 13.2 сая, Баянтал сумын ЗДТГ 6.3% 12.5 сая төгрөгөөр тус тус нэмж тодотгосон байна.

2017 оны төсвийг боловсруулж, батлахдаа баримтлах Сангийн сайдын өгсөн зөвлөмжийг бүрэн хангаж ажиллаагүй, төсвийг зарцуулахдаа УИХ-ын “төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх” гэсэн 47 дугаар тогтоолыг мөрдлөг болгоогүй байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол, УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн байна.

1.4. Орон нутгийн төсвийн тэнцлийн алдагдлыг нөхөх эх үүсвэрийг үнэн зөв тооцсон байна.

Аймгийн ИТХ-аар 2017 оны орон нутгийн төсөвт тэнцлийн алдагдлыг нөхөх эх үүсвэрийг 2016 оны ХБГ-ийг үндэслэн оны эхний үлдэгдэл 218.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр анх төлөвлөсөн боловч тайлант онд төсөвт 2 удаа тодотгол хийж, аймгийн ИТХ-ын 2017 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 06, Сүмбэр сумын ИТХ-ын 2017 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 04, Баянтал сумын ИТХ-ын 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 03, Шивээговь сумын ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 04 дугаартай тогтоолуудаар нийт 1,809.6 сая төгрөг болгон, 2016 оны жилийн эцсийн төсвийн хэмнэлт болон ОНХС-гийн гэрээний хэмнэлтийн бодит үлдэгдлийн нийт 1,591.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх

Бүлэг 2

Орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 761.2 сая төгрөг буюу 16.9%-иар давж биелсэн байна.

2.1. Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 15.6% буюу 636.6 сая төгрөгөөр давж биелсэн байна.

2017 онд орон нутгийн төсөвт татварын болон татварын бус орлого 4,508.6 сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 5,269.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 761.2 сая төгрөг буюу 16.9%-иар давж биелсэн байна.

2017 онд Сангийн яамнаас орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 4,288.1 сая төгрөгөөр хянагдаж ирсэн бөгөөд 2016 оны 12 дугаар сард аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 12.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 4,300.8 сая төгрөгөөр баталсан байна.


Тайлант онд төсөвт 2 удаа тодотгол хийж, орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг 207.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 4,508.6 сая төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн татварын орлогын сүүлийн 2 жилийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

Он	Татварын орлого		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
2017	4,082.2	4,718.8	115.6
2016	4,289.2	4,797.0	111.8

/сая төгрөгөөр/

Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
/2 жилээр/



Хүснэгтээс харахад орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 5.1%-иар бууруулан төлөвлөсөн бөгөөд 2016 онд орлогын төлөвлөгөө 11.8%-иар давж, орлогын төлөвлөгөөний биелэлт 111.8%-тай байсан бол тайлант онд төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэл 15.6%-иар давж биелсэн бөгөөд өмнөх оны гүйцэтгэлээс 1.6%-иар буурсан байна.

2017 оны татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэр төрлөөр нь гаргасан судалгааг хүснэгтээр харуулбал:

ТАТВАРЫН ОРЛОГЫН НЭР ТӨРӨЛ		Төлөв	Гүйц	Зөрүү
Татварын орлогын нийт дүн		4 082.2	4 718.8	640.4
1.1.Цалинхөлс түүнтэй адилтгах орлогын татвар		2 926.1	3 281.2	355.1
1.2.ХХОАТ-буцаан олголт		- 268.8	- 271.4	- 2.6
1.3.Орлогыг тодорхойлох боломжгүй иргэний татвар				-
1.4.Суутгагчийн хувь хүнд олгосон орлогын албан татвар		101.5	209.9	108.4
1.5.Үйл ажиллагааны орлого		43.0	44.2	3.2
1.6.Хөрөнгө худалдсаны орлогын албан татвар		35.0	39.7	4.7
1.7.Үл хөдлөх хөрөнгийн албан татвар		242.0	263.3	21.3
1.8.Бууны татвар		4.5	4.8	0.3
1.9.Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар		84.0	93.5	9.5
1.10. Улсын тэмдэгтийн хураамж		52.0	93.7	41.7
1.11.Газрын төлбөр		90.0	117.6	27.6
1.12. Усны төлбөр		585.5	598.6	13.1
1.13.Агнуурын нөөц ашигласны төлбөр			28.9	28.9
1.14.Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр		4.7	1.5	- 3.2
1.15.Хог хаягдлын үйлчилгээний хураамж		86.5	86.7	0.2
1.16.Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт		96.2	126.1	29.9

Хүснэгтээс харахад: татварын орлогын төлөвлөгөөний биелэлт нийт дүнгээрээ 640.4 сая төгрөгөөр давж биелсэн ба орлогын нэр төрлөөрөө 0.2-100.0%-иар буюу 0.1-355.1 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн шалтгааныг тодруулбал:

- Орон нутгийн орлогын төлөвлөгөөг өмнөх оноос бууруулж төлөвлөсөн,
- Тайлант оны жилийн эцэст төсвийн тодотгол хийхдээ орлогын гүйцэтгэлээр төлөвлөгөөг баталсан
- Өмнөх оны дутуу төлөгдсөн татварын орлогууд он дамжин төлөгдсөнтэй холбоотой байна.

Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

ТАТВАРЫН ОРЛОГЫН НЭР ТӨРӨЛ	2017 он		2016 он		Зөрүү	
	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц
1.1.Цалинхөлс түүнтэй адилтгах орлогын татвар	2 926.1	3 281.2	2 862.6	3 290.3	63,6	- 9,1
1.2.ХХОАТ-буцаан олголт	- 268.8	- 271.4	- 222.3	- 222.3	- 46,5	- 49,1

1.3.Орлогыг тодорхойлох боломжгүй иргэний татвар					-	-
1.4.Бусад татвар	101.5	209.9	67.1	91.7	34,4	118,2
1.5.Үйл ажиллагааны орлого	43.0	44.2	45.6	52.5	- 2,6	- 8,3
1.6.Хөрөнгө худалдсаны орлогын албан татвар	35.0	39.7	44.0	44.1	- 9,0	- 4,4
1.7.Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	242.0	263.3	240,0	262.3	2,0	1,0
1.8.Бууны татвар	4.5	4.8	4.0	5.9	0,5	- 1,1
1.9. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар	84.0	93.5	85.5	86.6	- 1,5	6,8
1.10. Улсын тэмдэгтийн хураамж	52.0	93.7	50.0	58.8	1,9	34,8
1.11.Газрын төлбөр	90.0	117.6	110.3	120.5	- 20,3	- 2,9
1.12. Усны төлбөр	585.5	598.6	901.7	902.8	- 316,3	- 304,3
1.13.Агнуурын нөөц ашигласны төлбөр		28.9			-	28,9
1.14.Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	4.7	1.5		1.4	4,7	0,1
1.15.Хог хаягдлын үйлчилгээний хураамж	86.5	86.7	80.7	82.2	5,7	4,5
1.16.Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт	96.2	126.1	19.9	19.9	76,3	106,2
НИЙТ ДҮН	4 082.2	4 718.8	4 289.2	4 797.0	- 207,0	- 78,2

Хүснэгтээс харахад татварын зарим нэр төрлийн орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 8 төрлийн орлогыг 0.5-76.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 6 төрлийн орлогыг 1.5-316.9 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 8 төрлийн орлого 0.1-118.2 сая төгрөгөөр давж, 7 төрлийн орлого 1.1-304.3 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Зарим орлогын төлөвлөгөө давж биелсэн нь төлөвлөх боломжгүй орлого болон зарим хуулийн өөрчлөлттэй холбоотой байна. Тухайлбал:

- Бусад татвар – өмнөх оны өр төлөгдсөн, мөн хадгаламжийн хүүгийн орлогын татвар шинээр нэмэгдсэнтэй холбоотой 118.2 сая,
- Үл хөдлөх хөрөнгийн албан татвар – үл хөдлөх хөрөнгийн тооллогоор үнэлгээг нэмэгдүүлсэн, өмнөх оны өр төлөгдсөнтэй холбоотой 1.0 сая,
- Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар – өөр татварын албанд бүртгэлтэй автомашины татварыг хураан авсантай холбоотой 6.8 сая,
- Улсын тэмдэгтийн хураамж – 2017 оноос газар өмчлөх эзэмшихтэй холбоотой УТХ төвлөрүүлдэг болсон, Шүүхийн шийдвэрээр улсын тэмдэгтийн хураамж төлөгдсөнтэй холбоотой 34.8 сая,
- Агнуурын нөөц ашигласны төлбөр – төлөвлөгдөөгүй орлогын дүн 28.9 сая,
- Хог хаягдлын хураамж – өмнөх оны өр төлөгдсөнтэй холбоотой 4.5 сая,
- Дуудлага худалдааны сонгон шалгаруулалт - дуудлага худалдааны болон дэнчингийн мөнгө төлөгдсөнтэй холбоотойгоор 106.2 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

2.2. Орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 125.3 сая төгрөг буюу 29.4%-иар давж биелсэн боловч орлогын нэр төрлөөрөө тасарсан байна.

2017 онд Сангийн яамнаас орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө 305.0 сая төгрөгөөр хянагдаж ирсэн бөгөөд уг дүнд өөрчлөлт оруулалгүй 2016 оны 12 дугаар сард аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор баталсан байна.

Тайлант онд төсөвт 2 удаа тодотгол хийж, орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөөг 121.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 426.3 сая төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

Он	Татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
2017	426.3	551.6	129.4
2016	645.7	718.6	111.3

Хүснэгтээс харахад: 2017 онд татварын бус орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 51.5% буюу 219.4 сая төгрөгөөр бууруулан баталсан бөгөөд гүйцэтгэлээр орлогын төлөвлөгөөг 29.4%-иар давуулан биелүүлсэн байна.

2017 оны татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг татварын нэр төрлөөр нь гаргасан судалгааг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
ТАТВАРЫН БУС ОРЛОГО		426,3	551,6	125,3
2.1.	Хүү, торгуулийн орлого	371,3	487,6	116,3
2.2.	Түрээсийн орлого	55,0	64,0	9,0

Хүснэгтээс харахад татварын бус орлого нийт дүнгээрээ 125.3 сая төгрөгөөр давж биелсэн бөгөөд түрээсийн орлого 9.0 сая төгрөг буюу 16.4%-иар давж биелсэн нь оны дундуур гэрээ байгуулагдсан, өмнөх оны өр төлөгдсөнтэй холбоотой байна.

ТЕЗ-ийн хэмжээнд төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 74.4% буюу 934.5 сая төгрөгөөр тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг 1,116.9 сая төгрөгөөр төлөвлөн батлуулсан ба 2 удаагийн төсвийн тодотголоор 139.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 1,256.7 сая төгрөгөөр батлуулсан байна. Өөрийн орлогын гүйцэтгэлийг мөнгөн гүйлгээний тайланд 416.9 сая төгрөгөөр тайлагнасан боловч төсвийн гүйцэтгэлийн тайланд 322.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Энэ нь “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын хог хаягдлын орлогыг Сүмбэр сумын орон нутгийн орлогод шууд төвлөрүүлдэг, Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн цалин илүү тооцсон зардлыг дансанд нь буцаан төвлөрүүлсэн, Халамжийн сангийн орон нутгийн орлогод төвлөрүүлсэн хүүгийн орлогын дүн, Нийтийн номын сан болон Биеийн тамир, спортын газруудын өөрийн орлогыг Төрийн сангийн дансанд төвлөрүүлэхэд төлсөн банкны үйлчилгээний шимтгэл зэрэгт тохируулга хийгдсэнтэй холбоотой байна.

Орон нутгийн төсөвт байгууллагын болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг диаграмаар харуулбал:



Орон нутгийн төсөвт байгууллагын болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой зэрэгцүүлсэн судалгааг байгууллага тус бүрээр харуулбал:

/сая төгрөгөөр/

№	Байгууллага	2017 он		2016 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Орон нутгийн төсөвт байгууллагын өөрийн орлого					
1	АЗДТГ	84,8	87,5	0.6	1.2
2	Цөм сүрэг үржлийн төв	30,9	32,5	31.1	29.6
3	Авто зам	24,3	25,6	18.6	19.0
4	Тохижилт-Сүмбэр				
5	Халамжийн сан		2,6	2.0	2.2
6	ГХБХБГ	9,3	9,3		1.8
7	ОНХС	8,8	8,8		
8	Сүмбэр ЗДТГ	-	-		0.2
Дүн		158,1	166,3	52.4	54.0
Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын өөрийн орлого					
1	БТСГ	22,0	21,6	18.7	19.6
2	Музей	0,5	0,5	0.5	0.5
3	Номын сан	0,5	0,8	0.5	0.5
4	Боржигон чуулга	18,4	25,0	25.0	22.0
5	Шивээговь СТөв	1,0	1,0	1.0	1.0
6	Баянтал СТөв	1,0	1,2	1.0	1.1
Дүн		43,4	50,1	46.7	44.7
Сумдын сангийн орлого					
1	Сумдын сум хөгжүүлэх сан	1 035,8	101,0	928.8	114.1
2	Сумдын Байгаль хамгаалах сан	4,3		35.0	3.4
3	Сумдын Мал хамгаалах сан	15,2	4,8	11.8	2.0
Дүн		1 055,2	105,8	975.7	119.5
НИЙТ ДҮН		1 256,7	322,2	1 074.8	218.2

Судалгаанаас харахад 2017 оны өөрийн орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 16.9%-иар буюу 181.9 сая төгрөгөөр нэмж төлөвлөсөн байна. Энэ нь сумдын СХС, БХС, МХС-гуудад орлогын төлөвлөгөө баталдаг болсон, төсвийн тодотголоор орон нутгийн төсөвт байгууллагуудын орлогыг гүйцэтгэлээр нь батлуулсантай холбоотой байна. Тухайлбал: Аймгийн ЗДТГ-ын өөрийн орлогын төлөвлөгөө 0.7 сая төгрөг боловч онцгой байдлын /шүлхийн/ санхүүжилтийн орлого 69.1 сая, цэргийн дүйцүүлэх албаны орлого 15.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн батлуулсантай холбоотой байна.

Өөрийн орлогын төлөвлөгөөг биеийн тамир, спортын газар 0.4 сая, Сумдын сангуудын орлого 949.4 сая төгрөг буюу 90%-иар тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэснийг тус тус зөрчсөн байна.

2.3. 2017 онд улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг аваагүй байна.

Тус аймаг 2016 онд 16.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч байсан бол 2017 онд улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг аваагүй байна.

2.4. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг бүрэн санхүүжигдсэн байна.

2017 онд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг УИХ-аас 1,185.0 сая төгрөгөөр хянаж, баталсан боловч МУ-ын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар 6.9 сая төгрөгөөр бууруулан 1,178.1 сая төгрөгөөр баталсан бөгөөд санхүүжилтийг бүрэн олгосон байна. Энэ нь холбогдох шийдвэрийн өөрчлөлтөөс АМНАТ болон АМХБАТЗ-ийн орлогоос хуваарилалт хийгдэхгүй болсонтой холбоотой байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/			
Он	ОНХС-гийн санхүүжилт		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
2017	1 178,1	1 178,1	100.0
2016	2 227.4	2 227.4	100.0

Хүснэгтээс харахад ОНХС-гаас олгох санхүүжилтийг 2017 онд өмнөх оноос 89.0%-иар бууруулан төлөвлөсөн бөгөөд санхүүжилтийг бүрэн олгосон байна.

2.5. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийг бүрэн олгосон байна.

2017 оны Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийг УИХ-аас 7,913.3 сая төгрөгөөр баталсан МУ-ын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар 178.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 8,091.6 сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авсан байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

Он	Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
2017	8 091.6	8 091.6	100.0
2016	7 758.3	7 758.3	100.0

Хүснэгтээс харахад: 2017 онд Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийг өмнөх оноос 4.3%-иар нэмэгдүүлэн төлөвлөсөн бөгөөд 2016-2017 онд 100.0%-ийн биелэлттэй байна.

2.6. Тэнцлийн ашгийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

2016 оны 12 дугаар сард аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 2017 оны орон нутгийн төсвийн тэнцлийн алдагдлыг анх 218.6 сая төгрөгөөр нөхөж санхүүжүүлэхээр төлөвлөн баталсан бөгөөд тайлант онд хийсэн 2 удаагийн төсвийн тодотголоор 1,591.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1,809.6 сая төгрөгөөр баталсан байна.

Тэнцлийн ашгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгааг өмнөх онтой харьцуулан хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

Он	Тэнцлийн ашиг		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
2017	1 809.6	1 809.6	100.0
2016	658.6	658.6	100.0

Хүснэгтээс харахад: 2017 онд тэнцлийн ашгийг өмнөх оноос 174.8%-иар нэмэгдүүлж баталсан бөгөөд тайлант онд бүрэн төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн төсвийг үр ашигтай, үнэн зөв зарцуулсан эсэх

Бүлэг 3

Төсвийн хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан боловч зарим зардлыг үр ашиггүй зарцуулсан байна.

3.1. ТЕЗ-ийн батлагдсан төсөв нийт дүнгээрээ хэмнэгдсэн хэдий ч төсвийн зарцуулалттай холбоотой зөрчил дутагдал байсаар байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэмжээнд 2017 онд нийт 16.844.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж батлуулснаас 14,733.5 сая төгрөг зарцуулж, төсөв 2,111.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Нийт хэмнэгдсэн зардлын 44.2% нь бодит бус хэмнэлт байна. Тухайлбал: ТЕЗ-ийн 2017 оны төсвийн зарлагад сумдын СХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс олгох

зээлийн дүнг оруулж баталсан боловч сангийн эх үүсвэр бүрдээгүйгээс зээл олголт төлөвлөсөн хэмжээгээр олгогдоогүй, мөн төсөвт байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө тасарсантай холбоотой төсөв хэмнэгдсэн мэт харагдаж байна.

ТЕЗ-ийн 2017 оны нийт төсвийн гүйцэтгэлийн 45.7% буюу 6,741.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт байгууллага, 54.3% буюу 7,992.3 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төсөв эзэлж байна.

Аудитаар ТЕЗ-ийн 2017 оны төсөв зарцуулалттай холбоотой дараах зөрчил дутагдал гарсан байна. Үүнд:

1. Зарим албан тушаалтны буруугаас ажлаас халагдсан хүмүүст шүүхийн шийдвэрээр 5 хүнд 56.8 сая төгрөгийг олгож төсвийг үргүй зарцуулсан байна.
2. Орон нутгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн зарцуулалт, бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 1,315.0 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад 708.3 сая төгрөгийн алдаа, зөрчлийн залруулга хийж, 12.7 сая төгрөгийн төлбөрийн акт бичиж, 27.0 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 567.0 сая төгрөгийн алдаа, зөрчил арилгуулах зөвлөмж өглөө.

Аудитаар төсвийн зарцуулалт, бүртгэл, тайлагналтай холбоотой дараах нийтлэг зөрчил дутагдал илэрсэн байна. Тухайлбал: ээлжийн амралтын мөнгийг буруу тооцоолсноос цалинтай давхардуулан олгосон, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр нэмэгдэл, урамшуулал олгох, албан томилолтын зардлыг илүү, дутуу тооцож олгох, данснаас дансанд хөрөнгө шилжүүлэхдээ зардлаар тайлагнасан, тоон мэдээллийг давтан тооцоолдоггүй, хянах үйл ажиллагаа хангалтгүйгээс зөрүүтэй тайлагнасан, аудитлагдсан тайланг зөрүүтэй нэгтгэсэн, ОНХС-ийн болон хөрөнгийн зардлаас дэд хөтөлбөр нэрээр урсгал зардлуудыг санхүүжүүлэх, зардлын зүйл ангийг буруу ангилж бүртгэх, нөөц сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах зэрэг алдаа зөрчлүүд байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.6.2, 6.3.2, 6.4.1, 16.5.5, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, ХХОАТ-ын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 79.1, энэ хуулийн 135 дугаар зүйлийн 135.1.3, Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1, Засгийн газрын 207 оны 354 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, ЗГ-ын 1995 оны 96 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Эрүүл мэндийн сайдын 2000 оны 166 дугаар тогтоолын 13, Сум хөгжлийн сангийн хөрөнгө бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” зэрэг хууль эрх зүйн актуудыг тус тус зөрчсөн байна.

Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын талаар

Тайлант онд ОНТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагууд 320.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зарцуулжээ.

Үүний 73.6%-ийг орон нутгийн төсвийн байгууллагууд, 11.5%-ийг Боловсрол, соёл, урлагийн салбарын байгууллага, 7.5%-ийг Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газар, 2.9%-ийг Эрүүл мэндийн салбарын байгууллагууд, 4.5%-ийг ГХБХБГ зарцуулжээ.

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нэмэлт санхүүжилт
Орон нутгийн төсвийн байгууллагууд	235.8
Боловсрол, соёл, урлагийн байгууллага	36.8
Эрүүл мэндийн салбарын байгууллага	9.2
Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газар	23.9
Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	14.5
Нийт дүн	320.2

3.2 Тайлант хугацаанд ТЕЗ-ийн тайлангийн авлага өмнөх оноос 8.9%, өглөг 198.9%-иар тус тус өссөн байна.

ТЕЗ-ийн хэмжээнд 2017 онд авлага 1,655.7 сая, өглөг 1,403.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан бөгөөд өмнөх оноос авлага 136.3 сая, өглөг 933.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Нийт авлагын 34.4 сая төгрөг нь орон нутгийн төсөвт байгууллагууд, 1,444.8 сая төгрөг нь төсөл сан, 148.7 сая төгрөг нь ОНӨААН, 27.8 сая нь ТЗШ-ийн байгууллагуудтай холбоотой байна.


Нийт өглөгийн 906.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт байгууллагууд, 343.6 сая төгрөг нь төсөл сан, 144.8 сая төгрөг нь ОНӨААН, 8.7 сая нь ТЗШ-ийн байгууллагуудтай холбоотой байна.

а/ Орон нутгийн төсөвт байгууллагуудын нийт авлага, өглөгийг насжилтаар нь авч үзвэл:

/сая төгрөг/

Насжилт	Авлага		Өглөг	
	Дүн	Хувь	Дүн	Хувь
30 хүртэл хоног	3.7	10.8	895.3	98.8
31-60 хоног		0.0		0.0
61-90 хоног		0.0		0.0
91-ээс дээш	30.7	89.2	10.7	1.2
Нийт дүн	34.4	100.0	906.0	100.0

Орон нутгийн төсөвт байгууллагуудын авлагын 10.8% буюу 3.7 сая төгрөг нь 30 хүртэлх, 89.2% буюу 30.7 сая төгрөг нь 91-ээс дээш хоногтой байна.



91-ээс дээш хоногтой 30.7 сая төгрөгийн авлага нь Баянтал сумын ЗДТГ-ын 4.2 сая, Баянтал сумын ИТХ-ын 0.1 сая, Аймгийн ИТХ-ын 2.3 сая, АЗДТГ-ын 0.9 сая, АЗДНС-гийн 0.5 сая, Цөм сүрэг үржлийн төвийн 22.7 сая төгрөг байна.

Өглөгийн 98.8% буюу 895.3 сая төгрөг нь 30 хүртэлх, 1.2% буюу 10.7 сая төгрөг нь 91-ээс дээш хоногтой байна. Үүнээс Каракуль хонины суурь байгуулахад зориулж төслөөс авсан зээл, урьдчилж орсон орлогоос 833.1 сая төгрөгийн өглөг үүссэн байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын авлага, өглөгийг насжилтаар нь авч үзвэл:

Насжилт	Авлага		Өглөг	
	Дүн	Хувь	Дүн	Хувь
30 хүртэл хоног	3.3	11.9	1.4	16.1
31-60 хоног		0.0	0.3	3.4
61-90 хоног		0.0	1.1	12.6
91-ээс дээш	24.4	88.1	5.9	67.8
Нийт дүн	27.7	100.0	8.7	100.0

2017 онд тусгай шилжүүлгийн байгууллагуудын авлага 91-ээс дээш хоногтой авлага нь Баянтал сумын соёлын төвийн 1.9 сая, Шивээговь сумын 3 дугаар сургууль 0.4 сая, 4-р сургууль 18.9 сая, шивээговь сумын 4-р Цэцэрлэг 2 сая, Баянтал сумын Эрүүл мэндийн төв 1.2 сая нийт 24.4 сая төгрөг байна.

2017 онд тусгай шилжүүлгийн байгууллагуудын өглөг 91-ээс дээш хоногтой авлага нь Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг 4.2 сая, аймгийн ГХБХБГ-ын 1.7 сая төгрөг байна.

3.3. Зөрчлийг илрүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагаа хангалтгүй, сургалт мэдээлэл дутмаг байна.

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, дотоод аудитыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Санхүүгийн хяналт, аудитын алба” 2015 онд аймгийн ЗДТГ-ын бүтцэд байгуулагдсан бөгөөд 2017 онд нийт 18 байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хамруулан шалгаж, 84.9 сая төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлж, 20.2 сая төгрөгийн

акт бичиж, зөрчил дутагдлыг арилгуулахаар 15 байгууллагад зөвлөмж, 19 албан шаардлага өгч ажилласан байна.

Тухайн тайлант хугацаанд хийгдсэн хяналт шалгалтаар дараах нийтлэг зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Албан томилолтын хоногийг засаж, илүү дутуу олгосон, анхан шатны баримтын бүрдлийг хангадаггүй /Засгийн газрын 218-р тогтоолын 1-р хавсралтаар баталсан журмын 12-р заалт/
- Автомашины шатахууны зарцуулалтыг тооцохдоо нормоос илүү бодож олгосон ба замын хуудсыг бөглөдөггүй /Дэд бүтцийн сайдын 2004 оны 19-р тушаалаар баталсан жишиг норм/
- Байгууллагын дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааны хувьд зарим байгууллага нь дотоод хяналтыг огт хийдэггүй, зарим байгууллага нь хяналт шалгалт хийсэн боловч шаардлага хангахгүй санхүүгийн үйл ажиллагаандаа бус үндсэн үйл ажиллагаандаа хяналтыг хэрэгжүүлдэг /ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоол /
- Удирдлагууд хүчингүй болсон хууль тогтоомжийг тушаал шийдвэрийн үндэслэл болгосон
- Ажлаас халагдсан ажилтнуудтай ээлжийн амралтын тооцоо хийдэггүйгээс ээлжийн амралтын олговор дутуу олгодог, мөн ээлжийн амралтын мөнгийг давхардуулан тооцож олгосон /Хөдөлмөрийн тухай хуулийн 55.1 дэх заалт/
- Ажилчдад цалингийн урьдчилгаа бодож олгохдоо цалингаас давсан хэмжээгээр олгодог боловч тухайн сард цалин хүрэлцэхгүй бол өглөг, авлагаар тусгадаггүйгээс ажилчдаас авах авлагаа дутуу суутгах /НББТХ-ийн 14.4.2 дахь заалт/
- ХЭДС-гийн эргэн төлөгдөх нөхцөлтэй олгож буй зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьдаггүй, зээл нь хугацаандаа төлөгдөөгүй иргэдэд ямар нэг хариуцлага тооцдоггүй
- Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэл хангалтгүй, үндсэн хөрөнгөө коджуулаагүй, элэгдлийн хугацаа дууссан үндсэн хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу ашиглах боломжгүй болсон хөрөнгийг холбогдох газарт нь санал хүргүүлж шийдвэрлүүлдэггүй /Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 зүйл /
- Шагнал урамшуулал олгохдоо ХХОАТ суутгадаггүй /Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 16.1.1, 23.1, 26.1.1 дэх заалтууд/

Дээрх зөрчлүүдийн улмаас Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, холбогдох журам, зааврууд зөрчигдсөөр байна.

Төсвийн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар жил бүр илэрсэн алдаа, зөрчлийн дүн буурахгүй, алдаа зөрчлийг давтсаар байгаа нь дотоод аудитын алба харьяа байгууллагуудынхаа санхүүгийн үйл ажиллагааг шалгах, зөрчлийг илрүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангуулах зэрэг үйл ажиллагаа хангалтгүй, сургалт мэдээлэл дутмаг байгаатай холбоотой байна.

3.4. “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулж, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Шилэн дансны тухай хуулинд төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу явуулахаас гадна салбарын хэмжээнд хяналт тавьж ажиллахаар заасан байна.

ОНТЕЗ-ийн харъяа байгууллагууд хуулинд заасан дээрх мэдээллүүдийг байгууллагын цахим хуудсанд байршуулж байгаа бөгөөд хэрэгжилтэд Төрийн аудитын байгууллага, аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хяналт тавьж ажилласан байна.

СХАА-наас 2017 оны 01 дүгээр сараас 11 дүгээр сар хүртэл төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, сан зэрэг нийт 75 байгууллагын шилэн дансны цахим хуудсанд мэдээ оруулалтанд тогтмол хяналт тавьж ажилласан байна.

Тус хяналтаар давхардсан тоогоор 55 байгууллагад албан тоот хүргүүлж, шилэн дансанд оруулбал зохих мэдээллийг нөхөн оруулуулж, 14 байгууллагад шилэн дансны мэдээ оруулалттай холбоотой хугацаатай албан шаардлага хүргүүлжээ. Албан шаардлагын биелэлт 100.0%-тай байна. Шилэн дансны мэдээ оруулалтанд тогтмол хяналт тавьснаар байгууллагууд мэдээ тайлангаа илгээдэггүй байсан бол 3 улирлын байдлаар 100.0% илгээсэн байна. Шилэн дансны цахим хуудасны мэдээ оруулалтын хугацаа хэтрэлт өмнөх онд 35.9% байсан бол энэ онд 15.0% болж 20.9%-иар буурчээ. Энэ нь шилэн дансны мэдээ оруулалтын чанар сайжирсныг харуулж байна.

Мөн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд тогтмол хяналт тавьж сар бүрийн 15-нд аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын тамгын газрын дарга болон Санхүү, төрийн сангийн хэлтсийг мэдээллээр ханган ажилласан байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд дараахь нийтлэг дутагдал илэрсэн байна.

- Төсвийн хэтрэлт хэмнэлтийн тайлбар бичдэггүй /ШДТХ-ийн 6.3.3 заалт/
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт байхад хийдэггүй. /ШДТХ-ийн 6.4.1 заалт/
- Шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан, тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албанд дараа сарын 15-ны дотор тайлагнана” гэж заасны дагуу мэдээ тайланг хугацаанд нь илгээдэггүй зөрчил нийтлэг илэрсэн. /Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт/ Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Цаашид “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулж, хяналтыг сайжруулах, байгууллагуудын шилэн дансны мэдээлэл хариуцсан ажилтнуудыг нэгдсэн нэг ойлголттой болгох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. 2017 оны төсвийн төслийг боловсруулахдаа Сангийн яамнаас өгсөн чиглэлийн заримыг нь бүрэн хангаж ажиллаагүй байна.
2. Орлогын эх үүсвэр нийт дүнгээрээ 78.5 сая төгрөг буюу 0.5%-иар тасарсан байна.
3. Тухайн жилийн орон нутгийн төсөвт тодотгол, нэмэлт өөрчлөлт оруулах, эцэслэн батлах хугацааг хуулиар тогтоогоогүйгээс Төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг баримтлахгүйгээр төвлөрсөн орлогын хэмжээтэй уялдуулан зарлагыг нэмэгдүүлж, төсөвт өөрчлөлт оруулж байна.
4. Орон нутагт төсвийн зардлын хэмнэлтээс үүссэн эх үүсвэрийг дараагийн төсвийн жилд бусад зардалд шилжүүлэн санхүүжүүлж байгаа нь орон нутгийн төсвийн зардал нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна.
5. Орон нутгийн холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй байгаагаас төсвийн орлого, зарлагыг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, батлуулаагүй байна.
6. ТЕЗ-ийн батлагдсан төсөв нийт дүнгээрээ хэмнэгдсэн хэдий ч, төсвийн зарцуулалттай холбоотой зөрчил дутагдал байсаар байна.
7. Орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 125.3 сая төгрөг буюу 29.4%-иар давж биелсэн боловч орлогын нэр төрлөөрөө тасарсан байна.
8. Тайлант хугацаанд ТЕЗ-ийн тайлангийн авлага өмнөх оноос 8.9%, өглөг 198.9%-иар тус тус өссөн байна.
9. Төсвийн хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан боловч зарим зардлыг үр ашиггүй зарцуулсан байна.
10. “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулж, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд Засаг даргад:

1. Төсвийн орлогын төлөвлөлтийг үндэслэлгүйгээр бууруулж батлуулахгүй байх, бодитой төлөвлөх
2. Жилийн дундуур төсөвт нөлөөлөх талаар гаргасан бодлогын шийдвэрийг дараагийн жилээс хэрэгжүүлдэг байх
3. Тухайн жилийн төсвийн тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, төсвийн орлогыг үндэслэлгүйгээр дутуу төвлөрүүлсэн Төсвийн захирагч болон төсвийн байгууллагын удирдлагатай хариуцлага тооцох
4. Төсвийн зардлыг бууруулах, үргүй зардлыг нэмэгдүүлэхгүй байхад анхаарч, сахилга хариуцлагыг дээшлүүлэх
5. Өглөг, авлагыг барагдуулахад анхаарч, өмнөх оны түвшингээс бууруулан ажиллах